



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	10,152.3	1,987.8	-8,164.5
Бараа материал	115,049.4	128,909.6	13,860.2
Үндсэн хөрөнгө	2,790,294.1	2,748,400.8	-41,893.3
Нийт хөрөнгө	2,915,495.8	2,879,298.3	-36,197.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,915,495.8	2,879,298.3	-36,197.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,915,495.8	2,879,298.3	-36,197.6

Авлага: Өмнөх оны татаас санхүүжилтийн 10,152.3 мянган төгрөгийн авлагын 8,769.5 мянган төгрөгийг барагдуулж 1,382.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Тайлант онд 605.0 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой авлага үүссэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг биелүүлж ажиллаагүй тул зөвлөмж хүргүүлэв.

Бараа материал: Сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 31,590.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг бүртгэж авсан нь бараа материалын дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө: Төсвийн хөрөнгөөр 11,484.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 124,759.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээж авсан байна. Тайланд онд нийт 193,666.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхөж 0.0 төгрөгийн үлдэгдэлтэй болсон нийт 134,662.1 мянган төгрөгийн анхны үнэтэй 92 ширхэг хөрөнгө байна.

Эдгээр хөрөнгүүдийг дахин үнэлж, хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх зөвлөмж хүргүүлэв.

Засгийн газрын хувь оролцоо: Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант оны үр дүн буюу 36,197.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,012,412.1 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байна.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

5.1.1. Үндсэн хөрөнгийн бүртгэл

Илрүүлэлт: үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхөж 0.0 төгрөгийн үлдэгдэлтэй болсон нийт 767,859.9 мянган төгрөгийн анхны үнэтэй 599 ширхэг хөрөнгө байна. Зарим хөрөнгө бараа, материалын хэмжих нэгж, тоо хэмжээний бүртгэл алдаатай эмх цэгцгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй бөгөөд “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн бүртгэл, эд хөрөнгийн тооллогын үр дүнг үндэслэн тухай бүр байгууллагын хөрөнгийг үнэлж, бүртгэлийг цэгцэлж ажиллах

5.1.2 Ахмадын сан

Илрүүлэлт: Түнэл сумын ЗДТГ нь “Ахмадын сан” байгуулаагүй бөгөөд тайлант онд тус байгууллагад ажиллаж байсан ахмад настнуудад зориулж нийт 1,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" заалт, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай тус тус нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад ажиллаж байсан ахмадуудад зориулж төсөв зарцуулахдаа Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын дагуу ахмадын сан байгуулж тус сангийн журмыг мөрдөж ажиллах

5.1.3 Авлага барагдуулах

Илрүүлэлт: Тайлант онд 605.0 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй ба "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өглөг үүсгэхгүй ажиллах.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлээгүй	1	0.0					1	0.0				
Ахмадын сан байгуулж ажиллаагүй	1	0.0					1	0.0				
Авлага барагдуулж ажиллаагүй	1	605.0					1	605.0				
Дүн	3	605.0					3	605.0				